



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн санхүүгийн аудитын тайлан.

Увс

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	СУМС гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,215,710,900.00	85,512,061,087.3	82,926,317,476.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	78,730,320,200.00	76,680,858,299.0	76,253,857,982.0
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,542,705,300.00	73,618,599.0	73,234,415.7
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,039,685,800.00	47,410,800.0	47,408,670.0
5	Үндсэн цалин	36,561,250,000.00	36,031,500.0	36,029,000.0
6	Нэмэгдэл	6,569,372,000.00	6,600.0	6,600.0
7	Унаа хоолны хөнгөлөлт	133,376,100.00	100.0	100.0
8	Урамшуулал	2,978,013,400.00	2,978,013.411	2,978,013.411
9	Гэрээт ажлын хөлс	1,797,674,300.00	1,797,674.300	1,797,674.300
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,479,541,200.00	6,479,541.256	6,479,541.256
11	Тэтгэврийн даатгал	4,557,705,200.00	4,557,705.108	4,557,705.108
12	Тэтгэмжийн даатгал	480,460,200.00	480,460.200	480,460.200
13	ҮОМШӨ-ний даатгал	384,364,600.00	384,364.600	384,364.600
14	Ажлалгүйдлийн даатгал	96,094,000.00	96,094.000	96,094.000
15	Эрүүл мэндийн даатгал	960,917,200.00	960,917.200	960,917.200
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,088,081,300.00	8,740,925,579.43	8,740,925,579.43
17	Гэрэл, шахилгаан	552,703,900.00	426,917,920.49	426,917,920.49
18	Тулш, халаалт	8,229,224,400.00	8,043,482,278.94	8,043,482,278.94
19	Цэвэр, бохир ус	256,757,300.00	219,582,360.00	219,582,360.00
20	Байрны түрээс	49,395,700.00	50,943,020.00	50,943,020.00
21	Хангамж, бараа материалын зардал	2,536,985,600.00	2,490,245,395.08	2,468,716,445.08
22	Бичиг хэрэг	194,504,900.00	190,755,332.70	189,391,682.70
23	Тээвэр, шатахуун	1,149,264,400.00	1,131,340,727.00	1,123,305,627.00
24	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	177,324,300.00	164,537,901.38	164,517,901.38
25	Ном, хэвлэл	49,212,900.00	45,294,900.00	45,294,900.00
26	Хог хаагдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	183,596,400.00	167,251,866.00	167,251,866.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	783,082,700.00	791,064,668.00	789,604,668.00
28	Нормативт зардал	2,817,978,000.00	2,476,384,372.80	2,476,384,372.80
29	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	754,719,700.00	749,803,457.00	749,803,457.00
30	Хоол, хунс	1,904,320,300.00	1,572,940,795.80	1,572,940,795.80
31	Нормын хувцас, зөөлөн элдэл	158,938,000.00	153,640,120.00	153,640,120.00
32	Эд хогшил, урсгал засварын зардал	1,570,366,600.00	1,544,790,322.00	1,523,823,272.00
33	Багаж, техник, хэрэгсэл	837,418,400.00	828,633,740.00	828,633,740.00
34	Тавилга	105,964,600.00	105,844,882.00	105,844,882.00
35	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	21,667,800.00	19,604,400.00	18,128,400.00
36	Урсгал засвар	605,315,800.00	590,707,300.00	590,707,300.00
37	Томиллолт, зочны зардал	260,315,400.00	204,210,400.00	204,210,400.00

Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн тэнцэл  
1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/17

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг /УВА-2022/01/НА-СТА/ хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /М.Бат-Амгалан/, ахлах аудитор /Б.Авирмэд/ нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200100066

АГУУЛГА

<b>Тайлан бэлтгэсэн:</b>	<b>Агуулга</b> <b>Товчилсон үг</b>	3
	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b> <b>Ерөнхий мэдээлэл</b>	4
<b>Дарга, тэргүүлэх аудитор</b>	<b>Бүлэг 1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2021 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.</b>	5
М.Батсуурь	1.1. Увс аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.	5
<b>Аудитын менежер</b>	1.2. Увс аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн зарлагыг Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Орон нутгийн 2021 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”, өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.	6
М.Бат-Амгалан		
<b>Ахлах аудитор</b>	<b>Бүлэг 2. Увс аймгийн орон нутгийн төсвийн татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 1,787.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.</b>	6
Б.Авирмэд	2.1. Орон нутгийн 2021 оны төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 116.4 хувиар биелүүлсэн байна.	
Аудитор	2.2. Орлогын бүх гүйлгээ тухайн Төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.	
Р.Аюуш		
А.Нанжидмаа	<b>Бүлэг 3. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлага төлөвлөснөөс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.</b>	8
2022 оны 04 дүгээр сар	3.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	3.2. Батлагдсан бүтэц, орон тоог 5 байгууллага хэтрүүлсэн байна.	
<b>Хаяг:</b>	<b>Бүлэг 4. Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэлээр 1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.</b>	11
Увс аймаг дахь Төрийн аудитын газар,	4.1. Нэгдсэн төсвийн урсгал тэнцэл төлөвлөснөөс 3,438.0 сая төгрөгөөр буурч 1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.	11
Улаангом сум, 3 дугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	4.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсвийг 54.1 сая төгрөгийн хэмнэсэн байна.	
	4.3. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн орлого төлөвлөснөөс 4,840.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.	
	4.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн орлого төлөвлөснөөс 296.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.	13
	4.5. Орон нутгийн төсөвт 6,138.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.	
	<b>Дүгнэлт</b>	
	<b>Холбогдох байгууллагын санал</b>	14
	<b>Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар</b>	

**Товчилсон үгийн тайлал:**

1	УИХ	Улсын Их Хурал
2	ҮАГ	Үндэсний аудитын газар
3	ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
4	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
5	БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт
6	ЭМ	Эрүүл мэнд
7	ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
8	НХХ	Нийгмийн хамгаалал хөдөлмөр
9	СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
10	ОН	Орон нутгийн
11	ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
12	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
13	ЭМТ	Эрүүл мэндийн төв

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

### 1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын төлөвлөгөөг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

### 2. Аудитын зорилт:

Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

### 3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Увс аймгийн Засаг даргын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, Халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын санг хамруулан судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

### 4. Аудитын арга зүй:

Аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 100, 200, 2000-2899, Монгол улсын Төрийн аудитын MNS 6817-4:2020, Санхүүгийн аудитын тулгуур зарчим, “Төрийн аудитын аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-ийн дагуу аудитын зорилго, зорилтын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт боловсруулав.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас аймаг, сумын төсөвт байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлага, зөвлөмжид дурдагдсан зөрчлийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

## 5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулж, чанарын хяналтыг хэрэгжүүлэн, багийг ахлах аудитор Б.Авирмэд ахалж, аудитор А.Нанжидмаа, Р.Аюуш нар төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

## 6. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын багц хуулиуд
- ❖ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- ❖ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- ❖ Татварын багц хууль
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

## 7. Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Аймаг, сумдын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтад “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу орон нутгийн 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 90,215.7 сая төгрөгөөр, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 90,215.7 сая төгрөгөөр баталжээ. 2021 онд нийт 86,980.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 3,235.0 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

**Бүлэг: 1 Увс аймгийн нэгдсэн төсвийн 2021 оны орлого,  
зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан  
төлөвлөсөн байна.**

**1.1. Увс аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны  
гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.**

Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн яамнаас төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 80,195.6 сая төгрөгөөр хянасан байна.

Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 4-1/7562 дугаар албан бичгээр ирүүлсэн “Орон нутгийн 2021 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”, өмнөх оны орлогын гүйцэтгэлийг тус тус үндэслэн орон нутгийн төсвийн орлогыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 3,644.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 83,840.4 сая төгрөгөөр анх баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу 2021 оны төсвийн тодотголыг боловсруулан, хэлэлцүүлж, орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 86,980.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

**Урсгал орлогын талаар:** Орон нутгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг нийт 15,418.9 сая төгрөгөөр баталснаас татварын орлогоос 10,888.6 сая, татварын бус орлогоос 4,530.3 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт:1 / сая.төг/

Үзүүлэлт	Сангийн ямны хянасан дүн	2021 он	
		Анх батлагдсан	Тодотгол
Б	1	2	3
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2021 оны төсвийн тухай хууль 2020.11.13	Аймгийн ИТХ-ын 2020.12.04 -ны 3/04 тогтоол	Аймгийн ИТХ-ын 2021.08.06 -ны 5/01 тогтоол
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	<b>10,801.0</b>	<b>14,445.8</b>	<b>15,458.9</b>
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	<b>80,195.6</b>	<b>83,840.4</b>	<b>86,980.7</b>
УРСГАЛ ОРЛОГО	<b>10,801.0</b>	<b>14,405.8</b>	<b>15,418.9</b>
Татварын орлого	9,937.0	10,444.8	10,888.6
Татварын бус орлого	864.0	3,961.0	4,530.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	<b>40.0</b>	<b>40.0</b>
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	<b>69,394.6</b>	<b>69,394.6</b>	<b>71,521.8</b>

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

**Тусламжийн орлогын талаар:** Орон нутгийн төсөвт 2021 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогоос 7,535.4 сая, улсын төсвөөс орон

нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 14,010.3 сая, улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоос 49,449.5 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусгай зориулалтын шилжүүлэг 526.6 сая, нийт 71,521.8 сая төгрөг оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт:2 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он	
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	76,902.2	69,394.6	71,521.8
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,308.4	7,209.5	7,535.4
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	24,641.9	13,317.6	14,010.3
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	46,607.4	48,340.9	49,449.5
ЭМД санхүүжих	344.5	526.6	526.6

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

**Хөрөнгийн орлогын талаар:** Орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөгийн хөрөнгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 86,980.7 сая төгрөгөөр тодотгон баталсныг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө**

Хүснэгт:3 /сая.төг/


№	Үзүүлэлт	2021 оны батлагдсан төсөв
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	86,980.7
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	15,458.9
<b>А</b>	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	15,418.9
<b>1</b>	<b>Татварын орлого</b>	10,888.6
<b>1.1</b>	<b>Орлогын албан татвар</b>	8,430.9
<b>1.1.1</b>	Хувь хүний орлогын албан татвар	8,995.9
<b>1.1.2</b>	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 565.0
<b>1.2</b>	<b>Өмчийн татвар</b>	777.4
<b>1.3</b>	<b>Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар</b>	380.0
<b>1.3.1</b>	Тусгай зориулалтын орлого	0.0
<b>1.3.2</b>	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	380.0
<b>1.4</b>	<b>Бусад татвар /төлбөр хураамж/</b>	1,300.3
<b>2</b>	<b>Татварын бус орлого</b>	4,530.3
<b>Б</b>	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	40.0
<b>Б-1</b>	Хөрөнгө борлуулсны орлого	40.0
<b>В</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>71,521.8</b>
<b>В-1</b>	ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	7,535.4
<b>В-2</b>	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	14,010.3

В-3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	49,449.5
В-4	ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	0.0
В-5	ЭМД санхүүжих	526.6

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Орон нутгийн төсвийн суурь орлогын 70.4 хувийг татварын орлогоос, 29.3 хувийг татварын бус орлогоос, 0.3 хувийг хөрөнгийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График 1



Татварын орлогын 77.4 хувийг хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

График 2



Нийт орлого ба санхүүжилтийн 82.2 хувийг тусламжийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

График 3



**1.2. Увс аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн зарлагыг Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Орон нутгийн 2021 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж, өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.**

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолуудаар орон нутгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 86,172.1 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 5/01 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолуудаар 90,215.7 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Төсвийн зарлагыг анх төлөвлөхдөө Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 4-ний 1/7562 дугаар албан бичгээр ирүүлсэн “Орон нутгийн 2021 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”, Сангийн яамнаас хянасан суурь төсвийн зарлагыг үндэслэсэн байна.

Тодотгол хийхдээ Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу өмнөх оны гүйцэтгэлд суурилсан ба Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, үндэс болгосон байна.

**Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө**

Хүснэгт:5 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он	
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	89,456.5	86,172.1	90,215.7
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	73,039.2	75,697.6	78,730.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,011.7	72,542.7	75,542.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,841.7	45,266.3	48,039.7

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,743.5	6,117.3	6,479.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,301.1	9,144.9	9,088.1
Хангамж, бараа материалын зардал	1,994.2	1,775.6	2,537.0
Нормативт зардал	3,532.4	5,583.2	2,818.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,421.3	735.4	1,570.4
Томилолт, зочны зардал	214.6	335.5	260.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,711.4	1,435.7	1,639.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,251.5	2,148.8	3,109.9
ТАТААС	32.5	28.0	28.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	32.5	28.0	28.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,995.0	3,126.9	3,159.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,239.3	1,224.0	1,230.9
Бусад урсгал шилжүүлэг	1,755.7	1,902.9	1,928.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,391.3</b>	<b>8,436.2</b>	<b>9,068.4</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,026.0</b>	<b>2,038.3</b>	<b>2,417.0</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>89,564.9</b>	<b>86,172.1</b>	<b>90,215.7</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>51,915.9</b>	<b>55,550.4</b>	<b>56,984.9</b>
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	46,607.5	48,340.9	49,449.5
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,308.4	7,209.5	7,535.4
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,907.0</b>	<b>27,229.1</b>	<b>29,268.9</b>
<b>Орон нутгийн төсвөөс</b>	<b>35,907.0</b>	<b>27,229.1</b>	<b>29,268.9</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,397.5</b>	<b>2,866.0</b>	<b>3,435.3</b>
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>344.5</b>	<b>526.6</b>	<b>526.6</b>

*Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/*

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өмнөх оноос өссөн нь 2021 оны төсөвт сум дундын эмнэлгийн төсвийг “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журам батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны хамтарсан 257/562 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцсон. Биеийн тамир, спортын газрын байр ашиглалттай холбоотой зардал, Сум дундын эмнэлгүүдийн байр ашиглалтын тогтмол зардал, урсгал засварын зардлыг орон нутгийн төсөвт тооцож тусгаснаас шалтгаалжээ.

Бараа, ажил үйлчилгээний зардлын 63.6 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, 8.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 12.0 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3.4 хувийг хангамж, бараа материалын зардал, 3.7 хувийг норматив зардал, 2.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.3 хувийг томилолт зочны зардал, 2.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 4.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

График 4



Урсгал зардлын 95.95 хувийг бараа үйлчилгээний зардал, 4.01 хувийг урсгал шилжүүлэг, 0.04 хувийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас байхаар төлөвлөсөн байна.

График 5



Нийт зардал цэвэр зээлийн дүнгийн 87.2 хувь нь урсгал зардал, 10.1 хувь нь хөрөнгийн зардал, 2.7 хувь нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байхаар төлөвлөсөн байна.

График 6



**БҮЛЭГ 2. Увс аймгийн орон нутгийн төсвийн татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 1,787.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.**

**2.1. Орон нутгийн 2021 оны төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 116.4 хувиар биелүүлсэн байна.**

Увс аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг тодотголоор 15,458.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 16,850.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт:6 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он		Гүйцэтгэл	Зөрүү
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв		
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	89,922.4	83,840.4	86,980.7	87,342.6	361.9
НИЙТ ОРЛОГО	13,020.2	14,445.8	15,458.9	16,850.9	1,392.0
УРСГАЛ ОРЛОГО	12,957.7	14,405.8	15,418.9	16,807.4	1,388.5
Татварын орлого	11,151.8	10,444.8	10,888.6	12,676.5	1,787.9
Орлогын албан татвар	8,537.0	8,126.2	8,430.9	9,290.1	859.2
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	9,121.6	8,776.2	8,995.9	9,855.0	859.1
<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	(584.6)	(650.0)	(565.0)	(564.9)	0.1
Өмчийн татвар	811.4	654.9	777.4	491.1	(286.3)
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	357.6	380.0	380.0	1,039.0	659.0
<b>Тусгай зориулалтын орлого</b>	-	-	-	632.0	632.0
<b>Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар</b>	357.6	380.0	380.0	407.0	27.0
Бусад татвар /төлбөр хураамж/	1,445.8	1,283.7	1,300.3	1,856.3	556.0
Татварын бус орлого	1,805.9	3,961.0	4,530.3	4,130.9	(399.4)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	62.5	40.0	40.0	43.5	3.5
<b>Хөрөнгө борлуулсны орлого</b>	62.5	40.0	40.0	43.5	3.5
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	<b>76,902.2</b>	<b>69,394.6</b>	<b>71,521.8</b>	<b>70,491.7</b>	<b>(1,030.1)</b>
<b>ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого</b>	5,308.4	7,209.5	7,535.4	7,535.4	-
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	24,641.9	13,317.6	14,010.3	14,010.3	-
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	46,607.4	48,340.9	49,449.5	48,509.9	(939.6)
ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	0.0	0.0	0.0	0.0	-
<b>ЭМД санхүүжих</b>	344.5	526.6	526.6	436.1	(90.5)


Эх сурвалж: /ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Тусламжийн орлогыг тодотголоор 71,521.8 сая төгрөгөөр баталж, 70,491.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаад доорх хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 939.6 сая төгрөг төвлөрүүлсэн.
- ЭМД-ийн сангаас гүйцэтгэлд суурилан санхүүжүүлснээс шалтгаалан 90.5 сая төгрөгийн санхүүжилт олгоогүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн суурь орлогыг 15,458.9 сая төгрөгөөр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 16,850.9 сая төгрөгийн татварын болон татварын бус, хөрөнгийн орлого төвлөрч төлөвлөгөөг 109.0 хувиар биелүүлсэн байна.

График 7



Орон нутгийн татварын орлого төлөвлөснөөс давж биелсэн ч татварын бус орлого 399.4 сая төгрөгөөр тасрахад сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Түүнчлэн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг аймаг сумын хурлаас баталж төлөвлөсөн ч Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжих дүнд оруулан төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнаснаас шалтгаалан тус орлого тасарсан мэт харагдаж байна.

Орон нутгийн төсвийн татварын орлогыг 10,888.6 сая төгрөгөөр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 12,676.5 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөг 116.4 хувиар биелүүлсэн байна.

График 8



Хувь хүний орлогын албан татвар 859.1 сая, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 556.0 сая, бууны татвар 27.0 сая, тусгай зориулалтын орлого 632.0 сая төгрөгөөр тус тус давснаас шалтгаалан 2021 оны татварын орлогын төлөвлөгөө 1,787.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

## 2.2. Орлогын бүх гүйлгээ тухайн төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.

Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу Төсвийн байгууллагуудын болон төсөл хөтөлбөр, сангийн орлого, зарлагын гүйлгээ нь Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжин хийгдсэн байна.

Сангийн сайдын 2011 оны 131/25/1289 тоот гэрээний дагуу арилжааны банкуудад татварын нэр төрлөөр нь “тэг” үлдэгдэлтэй данс нээж тухай бүр нь төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн байна.

**БҮЛЭГ 3. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлага  
төлөвлөснөөс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.**

**3.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.**

Увс аймгийн Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн зарлагыг 90,215.7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 85,512.0 сая төгрөгийн зарлага гарсан байна. Нийт батлагдсан төсөвт зардлыг 4,703.7 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар хэмнэлттэй зарцуулсан байна. Тайлант оны нийт зарлагын гүйцэтгэл нь өмнөх оноос 3,944.5 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэл болон төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа

Хүснэгт 7 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он			
		Анх батлагдсан	Тодотго сон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	89,456.50	86,172.10	90,215.70	85,512.00	-4,703.70
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	73,039.20	75,697.60	78,730.30	76,680.80	-2,049.50
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	70,011.70	72,542.70	75,542.70	73,618.50	-1,924.20
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,841.70	45,266.30	48,039.70	47,410.80	-628.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,743.50	6,117.30	6,479.50	6,206.90	-272.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,301.10	9,144.90	9,088.10	8,740.90	-347.2
Хангамж, бараа материалын зардал	1,994.20	1,775.60	2,537.00	2,490.20	-46.8
Нормативт зардал	3,532.40	5,583.20	2,818.00	2,476.40	-341.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1,421.30	735.4	1,570.40	1,544.80	-25.6
Томилот, зочны зардал	214.6	335.5	260.3	204.2	-56.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,711.40	1,435.70	1,639.80	1,553.90	-85.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,251.50	2,148.80	3,109.90	2,990.40	-119.5
<b>ХҮҮ</b>					-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр					-
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр					-
<b>ТАТААС</b>	32.5	28	28	26.5	-1.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас					-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	32.5	28	28	26.5	-1.5
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,995.00	3,126.90	3,159.60	3,035.80	-123.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,239.30	1,224.00	1,230.90	1,213.80	-17.1
Бусад урсгал шилжүүлэг	1,755.70	1,902.90	1,928.70	1,822.00	-106.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	15,391.30	8,436.20	9,068.40	7,919.10	-1,149.30
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	1,026.00	2,038.30	2,417.00	912.1	-1,504.90

Эх сурвалж: /ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 8 /сая.төг/

№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,300.2	2,216.1	84.1
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	20,694.1	19,255.1	1,439.0
3	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	176.3	164.8	11.5
4	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	169.5	167.8	1.7
5	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	900.0	890.0	10.0
6	Мал аж ахуйг хөгжүүлэх	569.5	569.5	0.0
7	Авто зам	345.0	344.9	0.1
8	Ойжуулалт	159.6	154.1	5.5
9	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	615.8	615.6	0.2
10	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	339.4	308.6	30.8
11	Газрын зураглал, кадастр	564.5	539.7	24.8
12	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	10,537.2	10,256.2	281.0
13	Биеийн тамир спорт	329.6	329.5	0.1
14	Соёл урлаг	3,718.5	3,648.7	69.8
15	Сургуулийн өмнөх боловсрол	12,260.1	11,644.5	615.6
16	Ерөнхий боловсрол	33,495.6	32,975.2	520.4
17	Нийгмийн халамж	145.2	91.1	54.1
18	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,447.1	926.7	1,520.4
19	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	31.9	31.9	0.0
20	Хүүхдийн хөгжил, хамгаалал	373.8	348.9	24.9
21	Ахмад настны хөгжил хамгаалал	42.7	33.1	9.6
<b>Нийт дүн</b>		<b>90,215.7</b>	<b>85,512.0</b>	<b>4,703.7</b>

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/


Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын улмаас Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой илүү цагийн нэмэгдэл хөлс олгоогүйгээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болон хоол хүнс, тогтмол зардлууд хэмнэгдсэн байна.
- ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байсны улмаас зээл олголт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.

Цалин хөлс ба нэмэгдэл урамшлын зардал 628.9 сая төгрөг буюу 1.3 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 272.6 сая төгрөг буюу 4.2 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 347.2 сая төгрөг буюу 3.8 хувиар, хангамж бараа материалын зардал 46.8 сая төгрөг буюу 1.8 хувиар, норматив зардал 341.6 сая төгрөг буюу 12.2 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 25.6 сая төгрөг буюу 1.6 хувиар, томилот зочны зардал 56.1 сая төгрөг буюу 21.5 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 85.9 сая төгрөг буюу 5.2 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 119.5 сая төгрөг буюу 3.8 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 9 /сая.төг/



Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна.


График 10 /сая.төг/



Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гүйцэтгэлээр авч үзвэл улсын төсвөөс 56,045.3 сая төгрөг буюу 64.4 хувийг, орон нутгийн төсвөөс 28,143.5 сая төгрөг буюу 32.3 хувийг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 2,444.6 сая төгрөг буюу 2.8 хувийг, эрүүл мэндийн даатгалын сангаас 436.1 сая төгрөг буюу 0.5 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг графикаар харуулбал:

График 11



Улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийг гүйцэтгэлээр харуулбал:

График 12



Улсын төсвийн санхүүжилтийн зардлын 86.5 хувь буюу 48,509.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 13.5 хувь буюу 7,535.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна.

### 3.2. Батлагдсан бүтэц, орон тоог 5 байгууллага хэтрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт 154 төсвийн байгууллага нэгтгэгдсэнээс 149 байгууллага нь батлагдсан бүтэц, орон тоогоор ажилласан байна. Харин Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “батлагдсан цалингийн сан, **орон тооны хязгаарт** багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасан байхад төсвийн 5 байгууллага бүтэц, орон тоогоо хэтрүүлэн ажилласан зөрчилд Төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоож, албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2 орлогч ажиллуулж 14.9 сая төгрөгийн цалин олгож төрд хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалын хавсралтаар баталсан гэрээт ажилтны орон тоог нэгээр хэтрүүлж 8.2 сая төгрөгийн цалин олгон төрд хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын орлогчийн 2 орлогч ажиллуулж 16.1 сая төгрөгийн цалин олгон төрд хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан гэрээт ажилтны тоо 5 гүйцэтгэлээр 6 гэрээт ажилтан ажиллуулж орон тоог 1-ээр хэтрүүлэн ажилласан зөрчилд албан шаардлага өгсөн байна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтэц орон тоог Аймгийн Засаг даргын 2020 оны А/43 дугаар захирамжаар 17-оор баталсан ч гүйцэтгэлээр 24 ажилтан ажиллаж, гэрээт ажилтны орон тоо батлагдаагүй байхад 7 орон тоогоор хэтрүүлэн ажилласан зөрчилд зөрчил арилгуулахаар албан шаардлага өгсөн байна.

Анх төлөвлөснөөс 6 байгууллага 9 орон тоогоор дутуу ажилласан байна.

Үүнд:

Хүснэгт 9

№	Байгууллагын нэр	удирдах		гүйцэтгэх		үйлчлэх		гэрээт		нийт		
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	зөрүү
1	Бөхмөрөн сумын ЕБС	1	1	35	34	11	11	2	2	49	48	1
2	Тариалан сумын ахлах сургууль	1	1	57	55	25	23	2	2	85	81	4
3	Тариалан сумын ЗДТГ	9	9	10	10	3	3	8	7	30	29	1
4	Ховд сумын Соёлын төв	1	1	3	2	1	1	1	1	6	5	1
5	Ховд сумын Эрүүл мэндийн төв	1	1	17	16	4	4	1	1	23	22	1
6	Улаангом сумын Соёлын төв	1	1	4	4	1	1	4	3	10	9	1
<b>дүн</b>		14	14	126	121	45	43	18	16	203	194	9

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад 2021 онд гүйцэтгэх ажилтан Бөхмөрөн сумын ЕБС 1, Тариалан сумын ЕБС 2, Ховд сумын Соёлын төв 1, Ховд сумын ЭМТ 1, үйлчлэх ажилтан Тариалан сумын ЕБС 2, гэрээт ажилтан Тариалан сумын ЗДТГ 1, Улаангом сумын Соёлын төв 1 орон тоогоор тус тус дутуу ажилласан байна.

**БҮЛЭГ 4. Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэлээр  
1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.**

**4.1. Нэгдсэн төсвийн урсгал тэнцэл төлөвлөснөөс 3,438.0 сая төгрөгөөр  
буурч 1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.**

Увс аймгийн 2021 оны төсвийн урсгал тэнцлийг 63,311.4 сая төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр урсгал тэнцэл 59,873.4 сая төгрөг байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэл

Хүснэгт 10 /сая. төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4	5=4-3
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>89,564.8</b>	<b>83,840.4</b>	<b>86,980.7</b>	<b>87,342.6</b>	<b>361.9</b>
<b>А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>12,600.1</b>	<b>14,405.8</b>	<b>15,418.9</b>	<b>16,807.4</b>	<b>1,388.5</b>
1 Татварын орлого	10,794.2	10,444.8	10,888.6	12,676.5	1,787.9
2 Татварын бус орлого	1,805.9	3,961.0	4,530.3	4,130.9	(399.4)
<b>Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>62.5</b>	<b>40.0</b>	<b>40.0</b>	<b>43.5</b>	<b>3.5</b>
<b>В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>76,902.2</b>	<b>69,394.6</b>	<b>71,521.8</b>	<b>70,491.7</b>	<b>(1,030.1)</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>89,456.5</b>	<b>86,172.1</b>	<b>90,215.7</b>	<b>85,512.0</b>	<b>(4,703.7)</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>73,039.2</b>	<b>75,697.6</b>	<b>78,730.3</b>	<b>76,680.8</b>	<b>(2,049.5)</b>
<b>1 Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>70,011.7</b>	<b>72,542.7</b>	<b>75,542.7</b>	<b>73,618.5</b>	<b>(1,924.2)</b>
1.1. Цалин, хөлс	45,841.7	45,266.3	48,039.7	47,410.8	(628.9)
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	5,743.5	6,117.3	6,479.5	6,206.9	(272.6)
Бараа, үйлчилгээний бусад					
1.3. зардал	18,426.5	21,159.1	21,023.5	20,000.8	(1,022.7)
<b>2 Зээлийн үйлчилгээний төлбөр</b>					-
<b>3 Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>3,027.5</b>	<b>3,154.9</b>	<b>3,187.6</b>	<b>3,062.3</b>	<b>(125.3)</b>
3.1. Татаас	32.5	28.0	28.0	26.5	(1.5)
3.2. Урсгал шилжүүлэг	2,995.0	3,126.9	3,159.6	3,035.8	(123.8)
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,391.3</b>	<b>8,436.2</b>	<b>9,068.4</b>	<b>7,919.1</b>	<b>(1,149.3)</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,026.0</b>	<b>2,038.3</b>	<b>2,417.0</b>	<b>912.1</b>	<b>(1,504.9)</b>
Эргэж төлөгдөх дотоод цэвэр					
1 зээл	1,026.0	2,038.3	2,417.0	912.1	(1,504.9)
Эргэж төлөгдөх гадаад цэвэр					
2 зээл					
<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	<b>(60,439.1)</b>	<b>(61,291.8)</b>	<b>(63,311.4)</b>	<b>(59,873.4)</b>	<b>3,438.0</b>
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>108.3</b>	<b>(2,331.7)</b>	<b>(3,235.0)</b>	<b>1,830.6</b>	<b>5,065.6</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР</b>					
<b>1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>	<b>(158.6)</b>			<b>1,830.6</b>	
<b>2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих</b>		2,331.7	3,235.0	<b>1,556.8</b>	
<b>3. Бусад</b>		2,866.0	3,435.3		

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэлээр 1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

**4.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсвийг 54.1 сая  
төгрөгөөр хэмнэсэн байна.**

Орон нутгийн төсвөөс Халамжийн санд 145.2 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 91.1 сая төгрөгийг 2 нэр төрлийн халамжийн үйлчилгээнд зарцуулж 54.1 сая төгрөг хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Халамжийн сангийн зарлагыг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт 11 /сая. төг/

№	Үзүүлэлт		Тайлант оны	
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Олон нийтийн оролцоон түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Өдрийн үйлчилгээ	20.4	15.8
		Сэргээн засах үйлчилгээ		4.5
2	Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж		124.8	70.8
<b>Нийт дүн</b>			<b>145.2</b>	<b>91.1</b>

Эх сурвалж: /Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын судалгаа/

Халамжийн сангийн төсөв хэмнэгдэхэд амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийг хэмнэсэн нь шууд нөлөөлсөн байна.

**1.3. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн орлого төлөвлөснөөс 4,840.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.**

Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 20,223.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 25,064.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 4,840.8 сая төгрөгөөр буюу 23.9 хувиар давуулан биелүүлжээ.

Хүснэгт 12 /сая.төг/

№	Нийгмийн даатгалын сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	17,736.4	21,732.9	3,996.5
2	Тэтгэмжийн даатгал	1,440.0	1,748.6	308.6
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	759.8	985.8	226.1
4	Ажилгүйдлийн даатгал	287.6	597.3	309.6
<b>Нийт дүн</b>		<b>20,223.8</b>	<b>25,064.6</b>	<b>4,840.8</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн судалгаа

Нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөө 4,840.8 сая төгрөгөөр давж биелэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 3,996.5 сая төгрөгөөр давж биелсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна. Тэтгэврийн даатгалын сангийн орлого давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Тухайн жилд нийгмийн даатгалын шимтгэл төлж, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан гаргасан 986 ажил олгогч байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 23 ажил олгогч буюу 2.4 хувиар өссөн.
- Өмнөх онтой харьцуулахад заавал даатгуулагчийн тоо 30 даатгуулагчаар нэмэгдсэн мөн “Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хууль үргэлжлэн хэрэгжсэнээр 1132 даатгуулагч хамрагдаж, 2.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлсэн нь төлөвлөснөөс 1.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн.
- Ковид цар тахлын үед ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын цалин 16-40.0 орчим хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Үндэсний статистикийн хорооны судалгаагаар аймгийн дундаж цалин 51.0 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зардал

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн нэр төрөл бүрээр 64,107.4 сая төгрөгийн зардал төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 62,653.7 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс 1,453.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт 13 /сая. төг/

№	Нийгмийн даатгалын сангийн зарлагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	59,993.4	58,532.4	1,461.0
2	Тэтгэмжийн даатгал	3,171.6	3,222.2	(50.6)
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	234.6	199.7	34.6
4	Ажилгүйдлийн даатгал	708.0	699.5	8.6
<b>Нийт дүн</b>		<b>64,107.4</b>	<b>62,653.7</b>	<b>1,453.6</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн судалгаа

Нийгмийн даатгалын зарлага төлөвлөснөөс 1,453.6 сая төгрөгөөр хэмнэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 1,461.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна. Тэтгэврийн даатгалын сангийн зарлага хэмнэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон иргэний тоог 2021 онд нэмэгдэнэ гэж төлөвлөсөн боловч өмнөх онтой харьцуулахад 230 иргэнээр буурсан.
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зардал 34.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь үйлдвэрлэлийн ослын хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмж 25.0 сая төгрөгөөр хэмнэгдэж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх болон рашаан сувиллын зардал гараагүйтэй холбоотой байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага нийт дүнгээрээ хэмнэгдсэн ч тэтгэмжийн даатгалын сангийн зардалд 50.6 сая төгрөгийг төлөвлөснөөс илүү зарцуулсан байна. Тэтгэмжийн даатгалын сангийн зардал төлөвлөснөөс хэтрэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авагчдын тоо 69 буюу 4.5 хувиар нэмэгдсэн.
- Коронавирусын өвчлөлтэй холбоотой хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авагчдын тоо 315 буюу 21.0 хувиар нэмэгдсэн
- Урьд онтой харьцуулахад жирэмсний болон амаржсаны дундаж тэтгэмж 129.5 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

#### 1.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн орлого төлөвлөснөөс 296.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 4,044.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 4,340.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөөг 296.1 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

Хүснэгт 14 /сая. төг/

№	Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл	3,503.20	3,851.3	348.1
2	Шимтгэлээ өөрөө төлдөг даатгуулагчийн шимтгэл	537.5	488.4	-49.1
3	Бусад орлого	3.5	0.64	-2.86
<b>Нийт</b>		<b>4,044.20</b>	<b>4,430.30</b>	<b>296.1</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 107.3 хувиар биелэхэд аж ахуй нэгж, байгууллагын шимтгэлийн орлого давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 20,807.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 15 /сая.төг/

№	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төрөл	2020 он Гүйцэтгэл	2021 он Гүйцэтгэл
1	Төрийн өмчийн эмнэлэг	4,231.70	8,354.40
2	Хувийн хэвшлийн эмнэлэг	752.7	1,054.80
3	Эмийн сан /зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт/	884.2	1,463.70
4	В, С вирусийн эм	117.4	94.7
5	Урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэг багц	135.7	177.9
6	В С вирусийн илрүүлэг баталгаажуулах, шинжилгээ	1	0.4
7	Эрүүл шүд-Эрүүл хүүхэд	128.3	0
8	Өрх, сумын ЭМТ	443	446
9	Ковидын тусламж хэвтэн эмчлүүлэх	0	6,792.20
10	Ковидын гэрийн тусгаарлалт	0	1,279.40
11	Ковидын вакцинжуулалт	0	593.6
12	Ковидын шинжилгээ /Тандалт/	0	50.1
13	Ковидын шинжилгээ /Сорьц/	0	500
<b>НИЙТ</b>		<b>6,694.00</b>	<b>20,807.20</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа*

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт өмнөх оноос 14,113.1 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна.

- Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг тайлант оноос гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсон.
- Ковид цар тахлын үеийн эмчилгээний болон шинжилгээ оношилгооны зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн.

**1.5. Орон нутгийн төсөвт 6,138.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.**

Орон нутгийн 2021 оны төсөвт нэмэлт санхүүжилтээр 6,138.2 сая төгрөгийн эх үүсвэр олгогдсоноос 6,099.0 сая төгрөгийг зарцуулж 39.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 16 /сая. төг/

Салбарын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он	
		Санхүүжилт	Зарцуулалт
БСШУС-ын сайд	593.8	344.7	344.7
ЭМ-ийн сайд	320.5	3,886.9	3,872.2
ГХБХБ-ын сайд	593.3	247.4	247.4
НХХ-ийн сайд	26.9	50.0	50.0
Засаг дарга	4,764.3	1,609.2	1,584.7
<b>Нийт дүн</b>	<b>6,298.8</b>	<b>6,138.2</b>	<b>6,099.0</b>

*Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/*

Орон нутгийн төсөвт 6,138.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос 160.6 сая төгрөгөөр буурсан байна.

## Дүгнэлт

Энэхүү санхүүгийн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2021 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.
2. Увс аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 1,787.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
3. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлага төлөвлөснөөс 4,703.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
4. Төсвийн 5 байгууллага бүтэц, орон тоогоо хэтрүүлэн ажилласан зөрчилд төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 39.3 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 56.6 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн байна.
5. Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэлээр 1,830.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Б.АВИРМЭД

АУДИТОР

А.НАНЖИДМАА

Р.АЮУШ

